



**“ОНЦГОЙ ДЭГЛЭМИЙН ХУГАЦААГ СУНГАХ ТУХАЙ”  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах бөгөөд Улсын Их Хурлын бусад шийдвэр тогтоолын хэлбэртэй байна.” гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.” гэж тус тус заасан.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Улсын эдийн засгийн амьдрал, хүн амын үйлчилгээний хэвийн нэхцэлийг хангахад нэн чухал үүрэг бүхий тодорхой үйлдвэрийн газар, байгууллагад шаардлагатай гэж үзвэл нийтлэг баримталдаг хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүйгээр 6 сар хүртэл хугацаагаар тусад нь онцгой дэглэм тогтоож, харьяалал харгалзахгүйгээр өөрийн шууд хяналтад авч ажиллуулах эрхийг БНМАУ-ын Засгийн газарт олгосугай.” гэж заасан.

Мөн хуулийн 3 дугаар зүйлд “Үйлдвэрийн газар, байгууллагад тогтоосон онцгой дэглэм, түүний хэрэгжилтийн явцыг сар бүр Улсын Бага Хурал, олон түмэнд мэдээлж байх, тухайн үйлдвэрийн газар, байгууллагад онцгой дэглэм тогтоосон нэхцэл байдал арилаагүй бол хугацааг нь сунгах тухай саналаа уул хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө БНМАУ-ын Бага Хуралд оруулж байхыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай. БНМАУ-ын Бага Хурал зайлшгүй шаардлагатай гэж үзвэл онцгой дэглэмийг нэг удаа 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.” гэж хуульчилсан.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 385 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 6 сарын хугацаагаар онцгой дэглэм тогтоож, онцгой дэглэмийн хугацаанд БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль болон тогтоолд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэн, компанийн үндсэн үйл ажиллагаа, удирдлага,

зохион байгуулалт, төлбөр тооцоог сайжруулж, орлогыг нэмэгдүүлэх асуудлыг шууд хариуцан гүйцэтгэж, компанийг бүрэн төлөөлөх эрх бүхий Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгчийг томилон ажиллуулж байна.

Онцгой дэглэм тогтоох үед "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн санхүү, төсвийн нөхцөл байдал хүндэрсэн, сахилга хариуцлага алдагдсан, нийт ажиллагсдын дунд удирдах албан тушаалтны эзлэх хувь өндөр, үйл ажиллагааны хэвийн нөхцөл алдагдсан, ил тод бус, хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөртэй холбоотой мэдээллийг нууцад хамааруулсан, ажлын гүйцэтгэл хоцрогдолтой байсан. Тодруулбал, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн худалдан авагчдад төлөх өр төлбөр 582 сая ам.доллар, бонд болон бусад урт хугацаат өр төлбөр 450 сая ам.доллар, гэрээт олборлогчдод төлөх өр төлбөр 123 тэрбум төгрөг байсан бөгөөд нийт 1.7 их наяд төгрөгийн мөнгөн хөрөнгийн дутагдалтай төсвийг батлуулсан байсан.

Иймд ашигт малтмал экспортлох буй нэр бүхий төрийн өмчит компаниуд болон экспортлох эрх бүхий этгээдүүдийн ашигт малтмалыг уурхайн ам нөхцөлөөр борлуулах шинэ гэрээ байгуулах явдлыг зогсоох, хүчин төгөлдөр гэрээ, хэлцлүүдийн хүрээнд экспорт, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулж, валютын мөнгөн орлогыг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдал улам бүр нэмэгдэхээс сэргийлэх, улсын төсөв, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, Төрийн хэмнэлтийн хуульд заасан санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлэх зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагын дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-д 6 сар хүртэл хугацаагаар онцгой дэглэм тогтоосон болно.

"Эрдэнэс Таван толгой" ХК-д тогтоосон онцгой дэглэмийн үед нүүрсийг биржээр, хил нөхцөлөөр борлуулж, нүүрсний үнэ, борлуулалтыг нэмэгдүүлсэн, нүүрс тээврийн зохион байгуулалтыг сайжруулж, тээврийн компаниудын үйл ажиллагааг дэмжсэнээр, тэдний төсөвт төлөх татварын хэмжээ нэмэгдсэн, компанийн тусгай зөвшөөрлийн талбайгаас нүүрс дутсан асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн, нүүрс худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг өөрчлөн, уурхайн ам.нөхцөлөөс, хил нөхцөлд шилжүүлсэн, уулын ажил гүйцэтгэх зардлыг бууруулсан, компанийн өр төлбөрийг барагдуулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлсэн, ил тод байдлыг хангах үүднээс нууцад хамруулсан төслийн гэрээнүүдийг ил тод болгосон, уурхайн хүчин чадлыг өсгөх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох, өртөг, зардлыг бууруулах төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлсэн, компанийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох ажлын хүрээнд шаардлагагүй алба нэгжийг татан буулгаж, удирдах ажилтны тоог бууруулсан, хууль зөрчсөн байж болзошгүй тохиолдлуудыг хяналт, шалгалтын байгууллагад гомдол гарган шилжүүлсэн зэрэг үр дүнгүүд гарч эхлээд байна.

"Эрдэнэс Таван толгой" ХК-д тогтоосон онцгой дэглэмийн үед шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр компанийн санхүүгийн нөхцөл байдал сайжирч, гадаад валютын орох урсгал нэмэгдсэн хэдий ч Тавантолгойн нүүрсний ордын эдийн засгийн өгөөж, үр ашгийг сайжруулах, нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх нүүрсний олборлолт, тээвэрлэлт, борлуулалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох, өртөг, зардлыг бууруулах, нээлттэй ил тод байдлыг хангуулах, нүүрсийг хил нөхцөлөөр биржээр арилжих зэрэг үйл ажиллагааг боломжит энэ түвшинд нь тогтвортой хадгалах, жигдруулэх, цаашид улам сайжруулж, үүссэн нөхцөл байдлыг бүрэн арилгах үүднээс "Эрдэнэс Таван толгой" ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагатай байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн засаглалыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 457 дугаар тогтоолоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар компанийн үндсэн үйл ажиллагаа болох уул уурхайн бүх шатны үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл, тайлاغнал, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт аудит хийлгэж, тайлан, дүгнэлтийг гаргуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэж, гэрээ шууд байгуулах аргаар тендер шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулан олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниудад тухай бүр урилга хүргүүлж, уулзалт зохион байгуулсан бөгөөд санхүүгийн өр төлбөрийн асуудлаас шалтгаалан оролцогч материал ирүүлээгүй тул хуульд заасны дагуу хэлэлцээ хийх арга хэмжээ авч, хэлэлцээний шатанд нэр бүхий олон улсад эрхтэй аудитын компанийтай хамтран ажиллах санаалаа хүргүүлэн урьдчилсан уулзалтыг хийж, үүсэх эрсдлийг үнэлэх арга хэмжээ хийгдэж байна.

Иймд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн засаглалыг сайжруулах, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог хангуулахаас гадна стратегийн ордын эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх, санхүүгийн болон бусад асуудлаар сахилга хариуцлага алдагдах, үйл ажиллагаа доголдохоос сэргийлэх зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгэж, гаргасан тайлан, дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээ авах үүднээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах нь зүйтэй байна.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилсан. Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн экспортод гаргах нүүрсийг цахимаар нээлттэй арилжих үйл ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нүүрсний нээлттэй цахим арилжааг 2023 оны 2 дугаар сарын 9-ний өдөр анх удаа зохион байгуулсан ба нийт 7 удаагийн арилжаагаар 416 мянган тонн нүүрсийг 53.9 сая ам.доллароор борлуулж, 20.9 сая ам.долларын нэмэлт орлого олсон. Биржийн арилжаагаар 224 мянган тонн коксжих нүүрс, 192 мянган тонн эрчим хүчиний нүүрсийг Ганцмод нөхцөлөөр борлуулсан.

Нүүрсийг хил нөхцөлөөр, биржээр борлуулснаар коксжих нүүрсний үнэ тонн тутамд 100-115 ам.доллар байсныг 178.6-182.1 ам.долларт, эрчим хүчиний нүүрсний үнэ тутамд 37 ам.доллар байсныг 70.3-73.3 ам.долларт хүрсэн. Иймд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа нүүрсний нээлттэй цахим биржийн уг арилжааг тогтвортой явуулах, дээрх хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээг хангуулах үүднээс “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах шаардлагатай болоод байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Төрийн бүтээмжийн сэргэлтийн хурээнд “Төрийн өмчит аж

ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна." гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолоор "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам", "Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам", "Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ыг тус тус батлан мөрдүүлж, холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, мэргэжлийн чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэх асуудлыг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар шийдвэрлэж ажиллах болно.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг сунгах асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсрууллаа.

#### **Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 4 заалттай байх бөгөөд "Эрдэнэс Тавантолгой" ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгах, уг онцгой дэглэмийн хугацаанд БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуульд заасан асуудлын хүрээнд шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болон тогтоолын хэрэгжилийг хангуулах, хяналт тавих, дагаж мөрдөх хугацааг тогтоохтой холбогдсон заалтыг тусгана.

#### **Гурав.Тогтоол батлагдсантай холбогдуулан үүсэх нийгэм, эдийн засгийн үр даавар**

"Эрдэнэс Тавантолгой" ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд сарын дундаж үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт, түүний өмнөх үеийнхтэй харьцуулахад эрс сайжирсан бөгөөд борлуулсан нүүрсний хэмжээ 4.1 дахин, тээвэр 3.9 дахин, экспорт 2 дахин, орлого 3.9 дахин, олборлолт 2.7 дахин тус тус өссөн эерэг үзүүлэлтийг тогтвортой хадгалснаар жилийн борлуулалтын орлогыг бүрэн бүрдүүлж, валютын орох урсгалыг нэмэгдүүлэх, тогтвормуулахад ихээхэн түлхэц болно.

Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хэрэгжүүлж байгаа нүүрсний нээлттэй цахим биржийн арилжаа тогтвортой явагдаж, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээ бүрэн хангагдах бололцоотой болж, нүүрсний олборлолт, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, нээлттэй, ил тод байдлыг хангах, нүүрсийг хил нөхцөлөөр, биржээр арилжих үйл ажиллагаа тогтвормиж, жигдрэх боломжтой болно.

Түүнчлэн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн засаглалыг сайжруулах, удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, мэргэжлийн чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэх, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийн дагуу хэрэгжүүлснээр стратегийн ач холбогдол бүхий ордын эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

**Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар.**

**"Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуультай тус тус нийцэх бөгөөд тогтоолын төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.**

-----oo-----